

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Улаангом сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/116/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2023 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Утас: 70453799, Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

УВС АЙМГИЙН УЛААНГОМ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
4 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Г.БАДАМХАТАН ТАНАА

2023.02.18 № УВА-2023/116/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Улаангом сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Увс аймгийн Улаангом сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн захирал өөрчлөгдсөн байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200200414

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	74,965,641.60	81,136,656.32
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	12,112,966.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	12,112,966.00
3121	Төгрөг	00.00	12,112,966.00
31211	Төрийн сангийн харилцах		
35	БАРАА МАТЕРИАЛ	74,965,641.60	69,023,690.32
351	Түүхий эд материал	11,662,473.00	12,702,676.44
35110	Тусгай зориулалттай материал	11,662,473.00	12,702,676.44
354	Хангамжийн материал	63,303,168.60	56,321,013.88
35470	Бусад хангамжийн материал	63,303,168.60	56,321,013.88
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,324,324,335.62	2,302,332,553.54
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,324,324,335.62	2,302,332,553.54
392	Биет хөрөнгө	1,963,191,835.73	1,942,543,386.89
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,458,654,588.37	2,476,654,588.37
39202	Хуримтлагдсан элэгдэл	-630,858,265.50	-721,113,454.38
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	199,198,276.74	268,163,076.74
39206	Хуримтлагдсан элэгдэл	-157,263,283.81	-176,803,891.10
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	112,815,655.63	121,815,655.63
39208	Хуримтлагдсан элэгдэл	-49,270,853.54	-60,640,556.65
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,001,700.00	5,001,700.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,426,700.00	-3,876,700.00
39217	Ном	28,340,717.84	33,342,968.28
393	Биет бус хөрөнгө	361,132,499.89	359,789,166.65
39301	Програм хангамж	5,504,860.00	5,504,860.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,972,360.11	-4,315,693.35
39303	Бусад биет бус хөрөнгө	358,600,000.00	358,600,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,399,289,977.22	2,383,469,209.86
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	2,570,902.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	2,570,902.00
413	Өглөг	00.00	2,570,902.00
4136	Бусад өглөг	00.00	2,570,902.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	2,570,902.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,399,289,977.22	2,380,898,307.86
51	Засгийн газрын хувь оролцоо	2,399,289,977.22	2,380,898,307.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
51101	Өмч: - төрийн	1,171,009,490.33	1,171,009,490.33
512	Хуримтлагдсан үр дүн	1,171,009,490.33	1,171,009,490.33
51210	Өмнөх үеийн үр дүн	576,361,978.31	557,970,308.95
51220	Тайлант үеийн үр дүн	576,361,978.31	576,361,978.31
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00.00	-18,391,669.36
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,399,289,977.22	2,383,469,209.86

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,421,581,655.12	1,873,874,553.88
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,392,792,864.12	45,270,753.88
120	Нийтлэг татварын бус орлого	978,992,940.12	45,270,753.88
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	978,992,940.12	45,270,753.88
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	28,788,791.00	1,828,603,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,560,605,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,560,605,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	267,998,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	267,998,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,517,619,576.04	1,892,266,223.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,517,619,576.04	1,892,266,223.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,468,418,137.04	1,789,875,923.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	988,928,250.00	1,198,433,375.00
210101	Үндсэн цалин	653,322,250.00	833,323,542.00
210102	Нэмэгдэл	270,729,000.00	315,868,574.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	360,000.00
210104	Урамшуулал	64,877,000.00	48,881,259.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	128,629,319.00	149,315,105.00
210201	Тэтгэврийн даатгал	89,175,419.00	101,102,305.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,863,500.00	12,053,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,890,800.00	9,642,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,972,700.00	2,410,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,726,900.00	24,106,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	224,727,924.00	234,339,402.00
210301	Гэрэл, цахилгаан	2,377,301.00	7,203,911.00
210302	Түлш, халаалт	219,279,200.00	219,279,200.00
210303	Цэвэр, бохир ус	3,071,423.00	7,856,291.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,317,660.00	21,976,104.72
210401	Бичиг хэрэг	932,000.00	4,618,850.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,028,890.00	275,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,724,900.00	6,484,100.00
210408	Бараа материал акталсны зардал	9,938,000.00	10,598,154.72
2105	Нормативт зардал	1,506,670.00	221,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	341,170.00	221,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,695,000.00	5,350,000.00
210604	Урсгал засвар	15,695,000.00	5,350,000.00
2107	Томилолт, зочны зардал	135,000.00	256,000.00
210702	Дотоод албан томилолт	135,000.00	256,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,858,900.00	18,242,584.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,130,000.00	5,047,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	806,400.00	806,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	812,500.00	12,388,384.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	85,619,414.04	161,741,752.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	26,024,360.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,076,591.00	12,758,560.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	75,542,823.04	122,958,832.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,201,439.00	102,390,300.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	44,933,200.00	102,390,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,223,200.00	102,390,300.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	903,962,079.08	-18,391,669.36
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	899,959,905.51	-18,391,669.36

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,442,588,715.00	1,828,603,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	28,788,791.00	1,828,603,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,560,605,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,560,605,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	267,998,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	267,998,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,442,588,715.00	1,816,490,834.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,442,588,715.00	1,816,490,834.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,393,387,276.00	1,714,100,534.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	988,887,962.00	1,198,433,375.00
210101	Үндсэн цалин	653,281,962.00	833,323,542.00
210102	Нэмэгдэл	270,729,000.00	315,868,574.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	360,000.00
210104	Урамшуулал	64,877,000.00	48,881,259.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	128,629,319.00	149,315,105.00
210201	Тэтгэврийн даатгал	89,175,419.00	101,102,305.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,863,500.00	12,053,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,890,800.00	9,642,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,972,700.00	2,410,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,726,900.00	24,106,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	224,727,924.00	231,768,500.00
210301	Гэрэл, цахилгаан	2,377,301.00	6,093,717.00
210302	Түлш, халаалт	219,279,200.00	219,279,200.00
210303	Цэвэр, бохир ус	3,071,423.00	6,395,583.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,320,000.00	5,350,000.00
210604	Урсгал засвар	16,440,000.00	5,350,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,708,900.00	17,436,184.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,130,000.00	5,047,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,662,500.00	12,388,384.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,189,591.00	111,797,370.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	93,226,760.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,189,591.00	18,570,610.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,201,439.00	102,390,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,933,200.00	102,390,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,223,200.00	102,390,300.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	12,112,966.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	12,112,966.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	12,112,966.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	812,409,490.33	00.00	189,048,352.89	1,001,457,843.22
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-00.13	-00.13
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	812,409,490.33	00.00	189,048,352.76	1,001,457,843.09
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	358,600,000.00	00.00	-77,698,357.19	280,901,642.81
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,171,009,490.33	651,918,508.58	576,361,978.31	2,399,289,977.22
2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,171,009,490.33	651,918,508.58	576,361,978.31	2,399,289,977.22
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,171,009,490.33	651,918,508.58	576,361,978.31	2,399,289,977.22
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-18,391,669.36	-18,391,669.36
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,171,009,490.33	651,918,508.58	557,970,308.95	2,380,898,307.86

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,560,605,200.00	1,548,492,534.00	12,112,666.00	99.2
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,560,605,200.00	1,548,492,534.00	12,112,666.00	99.2
Бараа, үйлчилгээний зардал	1,476,109,200.00	1,446,102,234.00	30,006,966.00	97.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,177,874,300.00	1,170,984,575.00	6,889,725.00	99.4
Үндсэн цалин	891,821,100.00	809,961,929.00	81,859,171.00	90.8
Нэмэгдэл	269,749,700.00	313,844,383.00	(44,094,683.00)	116.3
Унаа, болон бусад нөхөн олговор	-	317,000.00	(317,000.00)	-
Урамшуулал	16,303,500.00	46,861,263.00	(30,557,763.00)	287.4

Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	147,234,300.00	145,884,105.00	1,350,195.00	99.0
Тэтгэврийн даатгал	100,119,300.00	98,769,105.00	1,350,195.00	98.6
Тэтгэмжийн даатгал	11,778,800.00	11,778,800.00	-	100.0
ҮОМШӨ ний даатгал	9,423,000.00	9,423,000.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	2,355,700.00	2,355,700.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	23,557,500.00	23,557,500.00	-	100.0
Нормативт зардал	18,360,000.00	-	18,360,000.00	-
Хоол, хүнс	18,360,000.00	-	18,360,000.00	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	17,437,100.00	17,436,184.00	916.00	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,047,800.00	5,047,800.00	-	100.0
Мэдээллийн технологийн зардал	12,389,300.00	12,388,384.00	916.00	99.9
Бараа үйлчилгээний бусад зардал	115,203,500.00	111,797,370.00	3,406,130.00	97.0
Бараа үйлчилгээний бусад зардал	96,619,500.00	93,226,760.00	3,392,740.00	96.4
Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	18,584,000.00	18,570,610.00	13,390.00	99.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,496,000.00	102,390,300.00	(17,894,300.00)	121.1
Бусад урсгал шилжүүлэг	84,496,000.00	102,390,300.00	(17,894,300.00)	121.1
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	84,496,000.00	102,390,300.00	(17,894,300.00)	121.1
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,560,605,200.00	1,560,605,500.00	(300.00)	100.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,560,605,200.00	1,560,605,500.00	(300.00)	100.0
Улсын төсвөөс санхүүжих	1,560,605,200.00	1,560,605,500.00	(300.00)	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	12,112,966.00	(12,112,966.00)	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	78.00	78.00	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	70.00	70.00	-	100.0
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
Үйлчлэх ажилтан	7.00	7.00	-	100.0

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	267,998,300.00	267,998,300.00	-	100.0
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	267,998,300.00	267,998,300.00	-	100.0
Бараа, үйлчилгээний зардал	267,998,300.00	267,998,300.00	-	100.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	27,448,800.00	27,448,800.00	-	100.0
Үндсэн цалин	27,448,800.00	23,361,613.00	4,087,187.00	85.1
Нэмэгдэл	-	2,024,191.00	(2,024,191.00)	-
Унаа, болон бусад нөхөн олговор	-	43,000.00	(43,000.00)	-
Урамшуулал	-	2,019,996.00	(2,019,996.00)	-
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,431,000.00	3,431,000.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	2,333,200.00	2,333,200.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	274,400.00	274,400.00	-	100.0
ҮОМШӨ ний даатгал	219,600.00	219,600.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	54,900.00	54,900.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	548,900.00	548,900.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	231,768,500.00	231,768,500.00	-	100.0
Гэрэл цахилгаан	9,000,100.00	6,093,717.00	2,906,383.00	67.7
Түлш, халаалт	219,279,200.00	219,279,200.00	-	100.0
Цэвэр, бохир ус	3,489,200.00	6,395,583.00	(2,906,383.00)	183.3
Эд хогшил худалдан авах	5,350,000.00	5,350,000.00	-	100.0
Урсгал засвар	5,350,000.00	5,350,000.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	267,998,300.00	267,998,300.00	-	100.0
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	267,998,300.00	267,998,300.00	-	100.0
Орон нутгийн төсвөөс	267,998,300.00	267,998,300.00	-	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Улаангом сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн эрхэм зорилго: Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, хүүхэд сурах, хөгжих тэгш боломжийг бүрдүүлэн сургалтын чанар, үр дүнд ахиц гаргана.

Зорилт-1 Хүүхэд бүрийн ялгаатай байдлыг харгалзан амжилттай суралцахад, тэгш боломжийг бүрдүүлэн сургалтын үйл ажиллагааг чиглүүлэх

Зорилт-2. Хичээл сургалт болон хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар суралцагчдын бие хүний ур чадварыг хөгжүүлж, бие даан суралцахуйг дэмжсэн тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх

Зорилт-3. Ахлах ангийн суралцагчийн мэргэжил, хичээл сонголтод мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, технологийн дэвшил ашиглан суралцах боломжийг бүрдүүлэх, сургалтын арга, хэлбэрийг хөгжүүлэх

Зорилт-4. Хүүхэд бүрийн онцлогт нийцсэн боловсрол, хүүхэд хамгааллын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх

Зорилт-5. Зөвлөх багш нарын оролцоог нэмэгдүүлж, багш бүрийг ажлын байранд хөгжих боломжийг бүрдүүлэх

Зорилт-6. Багш, ажилтан бүр ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг эрхэмлэн харилцааны эерэг хандлага, соёл төлөвшүүлэх

Зорилт-7. Хүүхдийг шим тэжээллэг хоол хүнс хэрэглэх зохистой дадал хэвшилд сургах, сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанарыг сайжруулах

Зорилт-8. Цэцэрлэг, сургуулийн нэг хүүхдэд улсын төсвөөс олгох хувьсах зардлын санхүүжилтийг зориулалтын дагуу хамт олны оролцоотой төлөвлөж, хэрэгжилтийг үр дүнтэй, ил тод, нээлттэй хангах

Зорилт-9. Боловсролын байгууллагын гүйцэтгэлийн үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх тогтолцоог бүрдүүлж, сургуулийн менежментийг хэрэгжүүлнэ.

Зорилт-10. Сургуулийн "Дэмжлэгийн баг"-г эрчимтэй ажиллуулах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, анги удирдсан багш, хичээл заагч нарын оролцоог нэмэгдүүлэх, багшид нэмэгдэл хөлс олгох ажлыг хэрэгжүүлэн ажиллах

Зорилт-11. Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвийг түшиглэн судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлж, туршлагыг түгээн дэлгэрүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Ерөнхий боловсролын 4-р сургууль нь Захиргаа аж ахуй, Бага ангийн заах аргын нэгдэл, Байгалийн ухааны заах аргын нэгдэл, Нийгмийн ухааны заах аргын нэгдэл, Урлаг гоо зүйн нэгдэл гэсэн таван хэсэгтэй бөгөөд нийт 78 хүний орон тоотой үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Монгол улсын үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Ерөнхий боловсролын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хэмнэлтийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн захирлын 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/34 дүгээр тушаалаар тооллогын ажлыг зохион байгуулах

ажлын хэсэг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулж хөрөнгө бүртгэн авах, дутагдсан хөрөнгийг шийдвэрлүүлэх талаар санал дүгнэлтийг гаргажээ.

Захирлын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаангом сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,391.6 мянган төгрөгөөр буюу 0.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	12,112.9	12,112.9
Авлага	0	0	0
Бараа материал	74,965.6	69,023.7	-5,941.9
Үндсэн хөрөнгө	2,324,324.3	2,302,332.5	-21,991.8
Нийт хөрөнгө	2,399,289.9	2,383,469.2	-15,820.7
Өр төлбөр	0	2,570.9	2,570.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	0	0	0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,399,289.9	2,383,469.2	-18,820.7

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 12,112.9 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн шинэчлэл хэрэгжиж улсын төсвөөс санхүүжиж буй байгууллагуудын дансны үлдэгдлийг татан төвлөрүүлэхгүй байх шийдвэр хэрэгжсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 69,023.7 мянган төгрөг болж 5,941.9 мянган төгрөгөөр буурсан нь өмч хамгаалах зөвлөлийн шийдвэр гаргаж бусад хангамжийн материалыг акталснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,383,469.2 мянган төгрөг болж 15,820.7 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь Увс аймгийн ИТХ-ын 2022 оны 8/05 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгө актлах шийдвэр гарч тээврийн хэрэгслийг данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,383,469.2 мянган төгрөг болж 18,820.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн буурснаас шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,921.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийн зардлыг 93.2 мянган төгрөгөөр бууруулж 1,828.6 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь боловсрол шинэчлэлийн хүрээнд зардлын зүйл ангийг өөрчилсэнтэй холбоотой зарим зардлыг танасан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх нэг хөтөлбөрийн арван дөрвөн арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,828,603.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,560,605.5 мянган төгрөгийг улсын төсвөөс 267,998.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,560,605.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,548,492.5 мянган төгрөгийг зарцуулж 12,112.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Орон нутгийн төсвөөс 267,998.3 мянган төгрөг авч, урсгал зардалд 267,998.3 мянган төгрөг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,816,490.8 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,325.6 сая төгрөг буюу 98.3 хувьтай байгаа нь ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардал 20.8 сая төгрөгийг зарцуулаагүй үлдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Ерөнхий боловсрол-төрийн өмчийн барилгын тогтмол зардал: 71802-80111	231,768.5	231,768.5	0	100
2	Ерөнхий боловсрол-Нийтлэг үйлчилгээ: 71802-80112	36,229.8	36,229.8	0	100
3	Ерөнхий боловсрол-Байр ашиглалтын үйлчилгээ: 71802-80226	4,955.7	4,955.7	0	100
4	Ерөнхий боловсрол-Сургалт семинар: 71802-80312	2,477.9	2,477.9	0	100
5	Ерөнхий боловсрол-Эрүүл мэндийг дэмжих: 71802-81605	5,699.1	5,639.9	59.1	98
6	Ерөнхий боловсрол-Үдийн цай хөтөлбөр: 71802-81801	102,856.0	102,390.3	465.7	99
7	Ерөнхий боловсрол-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин: 71802-81816	59,940.0	56,964.8	2,975.2	95
8	Ерөнхий боловсрол-Боловсролын байгууллагын багш: 71802-81823	11,150.4	10,792.0	358.4	97
9	Ерөнхий боловсрол-Боловсролын стандарт, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах: 71802-81834	1,293,127.9	1,284,873.7	8,254.2	99
10	Ерөнхий боловсрол-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах: 71802-81835	69,148.7	69,148.7	0	100
11	Ерөнхий боловсрол-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн: 71802-81844	2,956.5	2,956.5	0	100
12	Ерөнхий боловсрол-Сурах бичгийн түрээс: 71802-81848	5,048.1	5,047.8	0.3	99
13	Ерөнхий боловсрол-3Г болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан: 71802-83602	600.0	600.0	0	100
14	Ерөнхий боловсрол-Нэмэлт-шатны төсвөөс хуваарилсан: 71802-83603	2,645.2	2,645.2	0	100
ДҮН		1,828,603.8	1,816,490.8	12,112.9	99.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар тайлант онд гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улаангом сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 1,517.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 15.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,892.2 сая төгрөгийн 1.0 хувь буюу 18.9 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 15.1 сая төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймгийн Улаангом сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн хувьд хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн. /АБ-4/ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 149 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Улаангом сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймгийн Улаангом сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарч үзэх чухал асуудал байхгүй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТЦУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Ч.МӨНХТОГТОХ/

2023 оны 02 сарын 17-ны өдөр